



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 55

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах, үндсэн хөрөнгөд  
үнэлгээ тогтоож, худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.2, 6.4.3, 6.4.6, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хулд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 475,151.04 /дөрвөн зуун далан таван мянга нэг зуун тавин нэгэн төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй мах, ногооны зоорийг нэгдүгээр хавсралтаар акталж, данснаас хасах, 146,260,055.68 /нэг зуун дөчин зургаан сая хоёр зуун жаран мянга тавин таван төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 50 хүүхдийн дотуур байрын барилгыг доорх газрын хамт хоёрдугаар хавсралтаар худалдах доод үнийг 15,000,000 /арван таван сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Хулд сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

3. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн), Хулд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ц.Баянзөв) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Дуудлагын худалдааг зохих хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавин ажиллах;

3.2 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

3.3 Үл хөдлөх хөрөнгийг акталж, акталснаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;


3.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.5 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 09 дугээр сарын 29-ний өдрийн  
55 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Хулд сумын Ерөнхий боловсролын сургуулийн актлах барилгын МЭДЭЭЛЭЛ						
д/ л	Хөрөнги йн нэр	Зориулалт	Хүчин чадал	Ашиглаялтгад орсон он	Ашиглал тын нийт хугацаа /жилийн/	Балансын ҮНЭ
Max 1 ногооны зоорь		Гиег хэмжэ э	ХЭМ ЖИХ НЭГЖ		Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэ л өртөг
						Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглаз 4. бусад/

Дүн

475,151.04 /дөрвөн зуун  
далан таван мянга нэг зуун  
тавин нэгэн төгрөг дөрвөн  
мөнгө/ төгрөг

475,151.04

0

1

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 09 дугээр сарын 29-ний өдрийн  
55 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Хулд сумын Ерөнхий боловсролын сургуулийн худалдах барилгын мэдээллийн

Д/Л	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал	Ашиглаялгад	Ашигтай түн нийт хугацаа /жилийн эхийн энэгээс эхийн тоо/	Балансын үнэ	Хуримтлагдсан эхийн элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	Догуур байр	Байр	Хүчинчдийн тоо	50	1979	43	146,260,055.68	146,260,055.68	15,000,000
							<b>146,260,055.68 /нэг зуун дочин зургаан сая хоёр зуун жаран мянга тавин таван төгрөг жаран найман мөнгө/ төгрөг</b>	<b>15,000,000 /арван таван сая/ төгрөг</b>	

Дүн